

**КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНГААС
2023 ОНД САНХҮҮЖИЛТ ОЛГОСОН
ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ**



КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНГААС 2023 ОНД САНХҮҮЖИЛТ ОЛГОХООР ШАЛГАРСАН ТӨСЛҮҮД

“УЛААНБААТАР” олон улсын кино наадам зохион
байгуулах төслийн хэрэгжилт

№	“Улаанбаатар” кино наадам зохион байгуулах төслийн мэдээлэл	
1	Төсөл хэрэгжүүлэгч	“Монголын урлагийн зөвлөл төв” Холбоо /НҮТББ/
2	КУДС-аас олгосон санхүүжилтийг кино үйлдвэрлэлийн аль үе шатны үйл ажиллагаанд зарцуулах	Кино наадмын бэлтгэл ажлыг хангах үе шат

“Монгол кино уралдаан”-д нийт 6 бүтээлээс Хангарьд шагналын эздээр 11 төрөлд шалгарууллаа.



- “Улаанбаатар” олон улсын XV дугаар кино наадмыг 2023 оны 10-р сарын 16-22-нд Улаанбаатар хотноо зохион байгуулсан.
- “Ирж яваа цаг” олон улсын кино форум: Баримтат кино, Бидний цаг үе кино хальсанд гэсэн 2 хэсэгтэй зохион байгуулагдаж 200 гаруй уран бүтээлчид хамрагдсан.
- “Авдраа удал” кино сургалт: Дууны найруулагчийн ур чадварын сургалт МҮОНТ-ийн “Студи-100”-д хийгдэж 20 орчим уран бүтээлчид сонгогдон оролцсон.

2023 оноос эхлэн наадмын хүрээнд Networking spot-ыг зохион байгуулж байгаа бөгөөд онцлох зочноор Каннын кино наадмын Director's Fortnight хэсгээс Camera D'Or шагналыг авсан “Inside the yellow cocoon shell” буюу “Шар хүр хорхойн бүрхүүл дотор” уран бүтээлийн эзэн Вьетнам улсын найруулагч Тьен Ан Фам кино бүтээл, туурвил зүйн болон өөрийн кино найруулгын онцлогийн талаар ярилцсан.



КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНГААС 2023 ОНД САНХҮҮЖИЛТ ОЛГОХООР ШАЛГАРСАН ТӨСЛҮҮД

“ХАРХОРУМ” олон улсын кино наадам зохион
байгуулах төслийн хэрэгжилт

№	“Хархорум” кино наадам зохион байгуулах төслийн мэдээлэл	
1	Төсөл хэрэгжүүлэгч	“Кино гүүр хөгжлийн холбоо” Холбоо /НҮТББ/
2	КУДС-аас олгосон санхүүжилтийг кино үйлдвэрлэлийн аль үе шатны үйл ажиллагаанд зарцуулах	<ul style="list-style-type: none"> • Кино наадмын бэлтгэл ажлыг хангах үе шат • Олон улсын кино наадам зохион байгуулах үе шат

Анхдугаар “Хархорум” олон улсын кино наадамд нийт 9 орны 14 кино нэр дэвшиж “Хүний эрхийг киногоор хүүрнэхүй”, “Киног олон улсын наадамд бэлтгэх нь” 2 сургалт, “Кино урлагаар дамжуулан хүний эрхийг тунхаглах нь” 1 форум зохион байгуулагдаж кино урлагийн салбарын 100 гаруй уран бүтээлч, оюутан залуус хамрагдсан.



- “Хархорум” олон улсын наадмын хүрээнд 6 хоногийн турш 15 орны 22 киноны 45 үзвэр Шангрила дахь Өргөө 3 кино театрын 3, 5 дугаар танхимуудад үзэгчдийн хүртээл болж, нийт 1500 гаруй үзэгч үзэж сонирхсон байна.
- Монгол, БНСУ, АНУ-ын нийт 5 шүүгч кино уран бүтээлүүдийг шүүсэн ба тэр дундаас Оскарын /баримтат кино төрөлд/ хоёр удаагийн шагналт найруулагч Малколм Кларк онцлох зочин шүүгч байлаа.